



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 6/42

Бор-Өндөр сум

Багш нарт улирлын ажлын гүйцэтгэл,
үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолын хавсралтын 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багшийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, дүгнүүлсэн багш нарын 2024 оны 02 дугаар улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшууллыг хавсралтад дурдсан нэрс, хувь хэмжээгээр олгосугай.

2.Улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшууллыг 2024 оны 06 дугаар сард бодож олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Н.АМАРЖАРГАЛ

